



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/49/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд сум
2020 он

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ч.Ариунаа

Утас: 99092469 Цахим хаяг: ariunaach@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 90077079 Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Уваа уул” аудит ХХК

Утас: 99108763 Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1. Аудитын гэрчилгээ


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

ДОРНОГОВЬ АЙМГИЙН МАНДАХ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ А.ЭНХМЭНД
ТАНАА

2020.02.28 № 1-6/200
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Мандах сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал А.Энхмэнд Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 02-ноос 2020 оны 02 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Уваа уул аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Уваа уул аудит” ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол ёс заншлаа эрхэмлэн дээдэлж, эх хэлээрээ зөв уншиж, бичихэд суралцахад оршино.

Тэргүүлэх зорилтууд:

- Багш нарын заах арга, ур чадварыг нэмэгдүүлэх,
- Өв уламжлалаараа дамжуулан зөв, уншиж бичих аргад суралцуулах,
- Зөв хүмүүжил төлөвшилтэй иргэн болгон төлөвшүүлж, суралцах суурь чадварыг нэмэгдүүлэх,
- Суралцагчдын суралцах, хөгжих явцад эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Суурь боловсрол эзэмшүүлэх,
- Насан туршийн боловсролын үйлчилгээг явуулж иргэдийн насан туршдаа хөгжих боломжийг бүрдүүлнэ гэжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 2018 оны 80 дугаар тогтоолоор “Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”
- Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр тушаал “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол “Журам шинэчлэн батлах тухай”
- Дорноговь аймгийн ИТХТогтоол 2019-06-10-ны 11/09 төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай
- Дорноговь аймгийн ИТХТогтоол 2019-12-04-ны 12/07 төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 501,576.4 мянган төгрөгөөс тооцон 5,015.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 5,015.7 мянган төгрөгөөр тооцсон. Төлөвлөлтийн үеэс өөрчлөлт ороогүй.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 52,343.7 мянган төгрөгөөр буюу 3,6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	43,841.8	47,101.9	3,260.1
Үндсэн хөрөнгө /элэгдэл тооцсон/	1,405,078.0	1,454,230.8	49,152.8
Нийт хөрөнгө	1,448,989.1	1,501,332.8	52,343.7
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,449,989.1	1,501,332.8	52,343.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,449,989.1	1,501,332.8	52,343.7

Бараа материалын дансны үлдэгдэл 3,260.1 мянган төгрөгөөр өмнөх оноос өссөн байгаа нь шинэ дотуур байртай болсоноор хүүхдийн ирц нэмэгдэж, хүүхдийн тоо 50-65-ын хооронд хэлбэлзэж хоолны зардал өссөн.

Бараа материалын дансны үлдэгдэлд 2018-2019 онд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй. Бараа материалын дансны үлдэгдэлд байгууллагын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай хангамжийн болон хүүхдийн хоол, бичиг хэргийн материал, түлээ, нүүрсний үлдэгдэл байна. Хэрэгцээнээс нөөцөлсөн бараа материал байхгүй.

Бараа материалын дансанд шилжүүлээгүй бүртгэлтэй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 123,316.9 мянган төгрөгөөр өссөн /төсвийн хөрөнгөөр 16,500.5 мянган төгрөгөөр, үнэ төлбөргүй 105,534.4 мянган төгрөгөөр/

нь мэдээлэл зүйн кабинетыг 9,745.0 мянган төгрөг, Багш хөгжлийн төвийг өрөөтэй болгох зорилгоор 6,350.0 мянган төгрөг номын фондоод 405.5 мянган төгрөг, хуучин дотуур байрыг 104,778.4 төгрөгөөр /орон нутгийн хөгжлийн сангийн төсвөөр/ ажилчдын орон сууц болгохоор засварлаж, хүлээн авсан 756.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ном /хандиваар болон үнэ төлбөргүй/ нэмэгдэж, үндсэн хөрөнгийн данс хооронд 1,282.0 мянган төгрөгийн /аудитын дүнгээр/ шилжүүлэлт хийсэнтэй тус тус холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс хооронд 1,282.0 мянган төгрөгийн шилжүүлэлт хийсэн, 27,615.2 мянган төгрөгийн хөрөнгө акталсан, нийт 28,897.2 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Биет бус хөрөнгө, Өр төлбөр, Урт хугацаат өр төлбөр дансдын үлдэгдэлд өөрчлөлт гараагүй. Өр төлбөр дансны үлдэгдэл байхгүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,501,332.8 мянган төгрөг болж, 52,343.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр нэмэгдсэн байна. Засгийн газрын санд өөрчлөлт ороогүй.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга хийгдээгүй.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Мандах сумын Ерөнхий боловсролын сургууль тайлант онд 418,009.1 мянган төгрөгийг улсын төсвөөс /тусгай зориулалтын шилжүүлгээс/, 20,742.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, нийт 438,752.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 438,752.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэхээр батлагдсан 5 хөтөлбөрт 430,400.1 мянган төгрөгийг зарцуулан, үлдэгдэл 8,351.9 мянган төгрөгийг, үүнээс улсын төсвийн санхүүжилтээс 1.0 мянган төгрөг, орон нутгийн санхүүжилтээс 8,250.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 430,400.1 мянган төгрөг буюу 98.1 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл хэмнэгдсэнтэй холбоотой байна. Оны эцэст Төсвийн гүйцэтгэлийн тайланд орон тоо бүрэн ажилласан харагдаж буй боловч оны дундуур сургалтын менежер-1, бага ангийн багш-1, дуу хөгжмийн багш-1, хими-биологийн багш-1 дутуу байсан байна.

Нэмэлт төсөв: Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 1,202.9 мянган төгрөгийн нэмэлт орлогыг /Сурах бичгийн үнэ 1,0259.0 мянган төгрөг, байрны түрээсийн орлого 177,0 мянган төгрөг/ бүрдүүлжээ.

Үүнээс БСШУЯаманд сурах бичгийн үнэнд 1,025.9 мянга төгрөг, хичээл үйлдвэрлэлийн зардалд 177.0 мянган төгрөг, нийт 1,202.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 6 эрсдэл тодорхойлж, нийт 19 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 85,087.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 84,523.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 564.8 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 564.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Мандах сумын Ерөнхий боловсролын сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 119 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 25,842.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснээс 25,842.3 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна. Хүүхдийн хоолны зардалд 25,842.3 мянган төгрөгийн материалыг тендер зарлалгүй бэлтгэсэн зөрчлийг арилгах 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 1-6/107 тоот албан шаардлага бичигдсэн байсан ба 2019 онд худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, зөрчлийг давтан гаргаагүй байна. Акт тавигдаагүй, зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 564.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тооцсон 5,015.7 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Цалингийн зардал данстай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт:

Тэтгэвэрт гараад тэтгэмжээ аваад ажиллаж байгаа 2 багшид Засгийн газрын 90-р тогтоолын дагуу олгогддог нэмэгдэл, урамшуулал, үр дүнгийн урамшуулалд 564.8 мянган төгрөгийг олгосон.

3.1.2. Эрсдэл:

Цалин хөлс болон урамшууллын зардлыг хууль, журмын дагуу олгосон эсэх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.1.1. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Сургуульд багш дутагдалтай байсан тул Аймгийн БСУГ-т хүсэлт тавьсны дагуу 2019 оны 9-р сарын 7-ны өдрийн 49 тоотор “цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг гэрээнд тусган баталгаажуулан ажиллуулж болно” гэсэн зөвшөөрөл ирсний үндсэн дээр гэрээ байгуулан, нэмэгдэл хөлс олгож ирсэн. Уг 2 багшийн 1 нь Мандах сумынх, 1 нь Сайншандаас ирсэн. Аудитаар нэмэгдэл хөлс олгосныг зөрчилд тооцож байгаа учир цаашид олгохгүй гэж уг 2 багшид танилцуулахад “Тэгвэл ажиллахгүй” гэсэн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	43,911,112.90	47,115,843.70
33	АВЛАГА	69,320.00	-
335	Бусад авлага	69,320.00	-
3351	Байгууллагаас авах авлага	69,320.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	43,841,792.90	47,115,843.70
351	Түүхий эд материал	79,000.00	-
354	Хангамжийн материал	43,762,792.90	47,115,843.70
35410	Бичиг хэргийн материал	1,002,116.00	2,470,466.00
35420	Аж ахуйн материал	29,581,562.90	24,903,187.70
35440	Түлш, шатах тослох материал	8,184,500.00	11,497,000.00
35460	Хүнсний материал	4,994,614.00	8,245,190.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,405,077,997.97	1,454,230,833.22
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,405,077,997.97	1,454,230,833.22
392	Биет хөрөнгө	1,393,061,997.97	1,442,214,833.22
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,471,359,628.00	1,576,138,061.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(210,763,650.00)	(248,492,661.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	115,194,092.66	112,602,448.66
39206	Хуримтлагдсан элэгдэл	(52,407,362.46)	(56,794,997.29)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	80,640,231.00	72,341,656.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(29,641,288.65)	(31,841,512.53)
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,322,480.00	9,322,480.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(398,333.39)	(1,348,333.43)
39217	Ном	9,756,200.81	10,287,691.81
393	Биет бус хөрөнгө	12,016,000.00	12,016,000.00
39301	Програм хангамж	130,000.00	130,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(130,000.00)	(130,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	12,016,000.00	12,016,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,448,989,110.87	1,501,346,676.92
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	30,523.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	30,523.00	-
413	Өглөг	30,523.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	30,523.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,448,958,587.87	1,501,346,676.92
51	Засгийн газрын хувь оролцоо	1,448,958,587.87	1,501,346,676.92
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	349,292,953.95	349,292,953.95
51101	Өмч: - төрийн	349,292,953.95	349,292,953.95
512	Хуримтлагдсан үр дүн	915,763,125.88	968,151,214.93
51210	Өмнөх үеийн үр дүн	915,763,125.88	915,763,125.88
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	52,388,089.05
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	183,902,508.04	183,902,508.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,448,989,110.87	1,501,346,676.92

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,242,354,556.66	553,964,473.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	779,024,656.66	115,212,473.00
120	Нийтлэг татварын бус орлого	779,024,656.66	115,212,473.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	779,011,156.66	107,763,233.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	626,700.00	1,202,900.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	778,384,456.66	106,560,333.00
120009	Бусад орлого	13,500.00	7,449,240.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	463,329,900.00	438,752,00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	463,329,900.00	418,009,00.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	20,742,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	394,236,374.22	499,544,383.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	394,236,374.22	499,544,383.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	379,346,666.22	472,406,039.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252,288,734.00	304,084,270.00
210101	Үндсэн цалин	148,670,099.00	222,175,204.00
210102	Нэмэгдэл	54,408,036.00	39,317,628.00
210104	Урамшуулал	22,392,600.00	42,591,438.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,974,432.00	36,880,396.00
210201	Тэтгэврийн даатгал	20,038,249.00	31,219,952.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,482,099.00	1,349,334.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,051,099.00	1,197,866.00
210204	Ажилгүйдлийн даатгал	462,749.00	283,022.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,940,236.00	2,830,222.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,129,489.00	15,448,756.00
210301	Гэрэл, цахилгаан	1,999,439.00	1,657,106.00
210302	Түлш, халаалт	11,430,050.00	12,883,450.00
210303	Цэвэр, бохир ус	700,000.00	908,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,218,250.80	9,683,500.20
210401	Бичиг хэрэг	2,962,427.00	2,324,940.00
210402	Тээвэр, шатахуун	1,951,265.00	1,989,030.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	100,000.00
210404	Ном, хэвлэл	1,445,925.00	1,025,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	531,885.00	792,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,326,748.80	3,451,630.20
2105	Нормативт зардал	26,053,122.00	24,810,804.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	291,300.00	229,600.00
210502	Хоол, хүнс	24,807,446.00	24,577,424.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	954,376.00	3,780.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,472,510.00	6,818,335.00

210602	Тавилга	1,971,200.00	-
210604	Урсгал засвар	7,501,310.00	6,818,335.00
2107	Томилолт, зочны зардал	968,000.00	1,747,200.00
210702	Дотоод албан томилолт	968,000.00	1,747,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	208,900.00	760,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	208,900.00	760,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,033,228.42	72,172,778.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	204,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	823,900.00	1,118,690.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,209,328.42	70,850,088.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,889,708.00	27,138,344.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,823,082.00	11,337,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,585,800.00	10,537,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,237,282.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,066,626.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,066,626.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	15,801,144.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	15,801,144.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	848,118,182.44	54,420,089.78
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	140,371,592.14	2,032,000.73
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	802,256.60	2,032,000.73
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	139,569,335.54	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(140,371,592.14)	(2,032,000.73)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	707,746,590.30	52,388,089.05

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	463,970,100	447,404,140
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	640,200	8,652,140
120	Нийтлэг татварын бус орлого	640,200	8,652,140
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	626,700	1,202,900
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	626,700	1,202,900
120009	Бусад орлого	13,500	7,449,240
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	463,329,900	438,752,000
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	463,329,900	438,752,000
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	20,742,900
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	362,461,000	430,903,649
21	УРСГАЛ ЗАРДАЛ	362,461,000	430,903,649
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	347,571,292	403,765,305
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252,288,736	304,084,270
210101	Үндсэн цалин	148,670,100	222,175,204
210102	Нэмэгдэл	54,408,036	39,317,628
210104	Урамшуулал	22,392,600	42,591,438
210105	Гэрээт ажлын хөлс	26,818,000	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,986,707	36,910,919
210201	Тэтгэврийн даатгал	20,742,098	27,103,719
210202	Тэтгэмжийн даатгал	2,428,810	2,028,300
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,929,244	2,384,900
210204	Ажилгүйдлийн даатгал	1,016,173	490,300
210205	Эрүүл мэндийн даатгал	4,870,382	4,903,700
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,291,439	18,742,806
210301	Гэрэл, цахилгаан	1,999,439	1,657,106
210302	Түлш, халаалт	13,592,000	16,177,500
210303	Цэвэр, бохир ус	700,000	908,200
2104	Хангамж, бараа материалын зардал	4,681,150	5,171,870
210401	Бичиг хэрэг	327,170	540,290
210402	Тээвэр, шатахуун	2,663,815	2,007,480
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	370,000
210404	Ном, хэвлэл	-	1,025,900
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	531,885	792,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,158,280	436,200
2105	Нормативт зардал	27,019,620	29,006,000
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	408,000	408,000

Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210502	Хоол, хүнс	25,842,320	27,828,000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	769,300	770,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,327,480	2,169,040
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,070,000	520,000
210602	Тавилга	2,050,000	-
210604	Урсгал засвар	2,207,480	1,649,040
2107	Томилолт, зочны зардал	968,000	1,747,200
210702	Дотоод албан томилолт	968,000	1,747,200
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	208,900	760,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	208,900	760,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,799,260	5,173,200
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	204,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,799,260	4,969,200
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,889,708	27,138,344
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,823,082	11,337,200
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,585,800	10,537,200
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,237,282	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	800,000
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,066,626	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,066,626	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	7,449,240
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,449,240
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	8,351,904
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	8,351,904
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	101,509,100	16,500,491
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	101,509,100	16,500,491
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	101,509,100	16,500,491
2200	Дотоод эх үүсвэрээр	101,509,100	16,500,491
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	101,509,100	16,500,491
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(101,509,100)	(16,500,491)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	349,292,953.95	183,902,508.04	915,763,125.88	1,448,958,587.87
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	52,388,089.05	52,388,089.05
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	349,292,953.95	183,902,508.04	968,151,214.93	1,501,346,676.92

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	438,752,000.00	430,400,096.00	8,351,904.00	98.1
УРСГАЛ ЗАРДАЛ	438,752,000.00	430,400,096.00	8,351,904.00	98.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	427,393,200.00	419,062,896.00	8,330,304.00	98.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	310,385,000.00	304,084,270.00	6,300,730.00	98.0
Үндсэн цалин	226,823,000.00	222,175,204.00	4,647,796.00	98.0
Нэмэгдэл	40,073,000.00	39,317,628.00	755,372.00	98.1
Урамшуулал	43,489,000.00	42,591,438.00	897,562.00	97.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,935,600.00	36,910,919.00	2,024,681.00	94.8
Тэтгэврийн даатгал	27,756,200.00	27,103,719.00	652,481.00	97.6
Тэтгэмжийн даатгал	2,235,900.00	2,028,300.00	207,600.00	90.7
ҮОМШӨ-ний даатгал	2,794,900.00	2,384,900.00	410,000.00	85.3
Ажилгүйдлийн даатгал	559,000.00	490,300.00	68,700.00	87.7
Эрүүл мэндийн даатгал	5,589,600.00	4,903,700.00	685,900.00	87.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,742,900.00	18,742,806.00	94.00	100.0
Гэрэл, цахилгаан	1,959,300.00	1,657,106.00	302,194.00	84.6
Түлш, халаалт	15,983,600.00	16,177,500.00	-193,900.00	101.2
Цэвэр, бохир ус	800,000.00	908,200.00	-108,200.00	113.5
Хангамж, бараа материалын зардал	4,552,400.00	4,551,461.00	939.00	100.0
Бичиг хэрэг	300,000.00	540,290.00	-240,290.00	180.1
Тээвэр, шатахуун	2,550,400.00	2,007,480.00	542,920.00	78.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	736,000.00	370,000.00	366,000.00	50.3
Ном, хэвлэл	406,000.00	405,491.00	509.00	99.9
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	792,000.00	-542,000.00	316.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	310,000.00	436,200.00	-126,200.00	140.7
Нормативт зардал	29,006,100.00	29,006,000.00	100.00	100.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	408,000.00	408,000.00	00.00	100.0
Хоол, хүнс	27,828,100.00	27,828,000.00	100.00	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	770,000.00	770,000.00	00.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	17,885,000.00	17,884,040.00	960.00	100.0
Багаж, техник, хэрэгсэл	9,885,000.00	9,885,000.00	00.00	100.0
Тавилга	6,000,000.00	6,000,000.00	00.00	100.0
Урсгал засвар	2,000,000.00	1,999,040.00	960.00	100.0
Томилолт, зочны зардал	1,750,000.00	1,747,200.00	2,800.00	99.8
Дотоод албан томилолт	1,750,000.00	1,747,200.00	2,800.00	99.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	760,000.00	760,000.00	00.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	760,000.00	760,000.00	00.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	5376200.00	5376200.00	00.00	100.0
Бараа үйлчилгээний бусад	204,000.00	204,000.00	00.00	100.0

Дорноговь аймгийн Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

зардал				
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,172,200.00	5,172,200.00	00.00	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11358800.00	11337200.00	21,600.00	99.8
Бусад урсгал шилжүүлэг	11,358,800.00	11,337,200.00	21,600.00	99.8
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,558,800.00	10,537,200.00	21,600.00	99.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	438,752,000.00	438,752,000.00	8,351,904.00	98.1
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	418,009,100.00	409,658,250.00	8,350,850.00	98.0
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	418,009,100.00	409,658,250.00	8,350,850.00	98.0
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	20,742,900.00	20,741,846.00	1,054.00	99.9
Орон нутгийн төсвөөс	20,742,900.00	20,741,846.00	1,054.00	99.9

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,202,900.00	1,202,900.00
УРСГАЛ ЗАРДАЛ	1,202,900.00	1,202,900.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,202,900.00	1,202,900.00
Хангамж, бараа материалын зардал	1,025,900.00	1,025,900.00
Ном, хэвлэл	1,025,900.00	1,025,900.00
Бараа үйлчилгээний бусад зардал	177,000.00	177,000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	177,000.00	177,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,202,900.00	1,202,900.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	1,202,900.00	1,202,900.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,202,900.00	1,202,900.00

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Мандах сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2019.12.31			ДГА-2020/49/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Мандах сумын Ерөнхий боловсролын сургууль		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тооцооны дансаар дамжуулалгүй зардалд шууд бичсэн.	16,794.80	Дансны бичилтийг залруулах	Захирал Нягтлан бодогч	А.Энхмэнд Т.Мөнхтуяа
2	Хөдөлмөрийн чадвараа түр алдсан болон жирэмсэн эхийн тэтгэмжийн мөнгийг нийгмийн даатгалын газраас авахаар тооцсон үед орлого, мөнгөн хөрөнгө дансыг харьцуулж, дансны бичилт буруу хийж байна.	3,623.80	Дансны бичилтийг залруулах	Захирал Нягтлан бодогч	А.Энхмэнд Т.Мөнхтуяа
3	Хөдөлмөрийн чадвараа түр алдсан тэтгэмжийн мөнгийг байгууллагаас олгохоор тооцсон үед зардал, мөнгөн хөрөнгө дансыг харьцуулж, дансны бичилт буруу хийж байна.	334.30	Дансны бичилтийг залруулах	Захирал Нягтлан бодогч	А.Энхмэнд Т.Мөнхтуяа
4	Хүнс, шатахуун, түлээ, нүүрс, бичиг хэргийн болон аж ахуйн материал, эмийн зарлагыг сарын эцэст бөөн дүнгээр бүртгэж байна.	62,488.10	Дансны бичилтийг залруулах	Захирал Нягтлан бодогч	А.Энхмэнд Т.Мөнхтуяа
5	Тоног төхөөрөмжийг тавилгад бүртгэн, дансны ангилал буруу хийсэн.	1,282.00	Дансны бичилтийг залруулах	Захирал Нягтлан бодогч	А.Энхмэнд Т.Мөнхтуяа
6	Тэтгэвэрт гараад тэтгэмжээ авсан 2 багшид ЗГ-ын 90-р тогтоол, ҮДУ, урамшуулал олгосон.	564.80	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	А.Энхмэнд Т.Мөнхтуяа